

Э-Сонин

40 дахь дугаар



Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

“МОНГОЛ-ЛОНДОНГИЙН БИЗНЕС ФОРУМ”



“ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ” ХК- ИЙН 1072 ШИРХЭГ ХУВЬЦААНЫ ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

СТАНДАРТ ИНВЕСМЕНТ ҮЦК-ИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭВ



“МИК ХОЛДИНГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

“ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 4 дүгээр сарын арилжааны мэдээлэл.
- Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн бирж хоёр хамтран 5 дахь жилдээ “Монгол-Лондонгийн бизнес форум”-ыг 2016 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг түүний хоёр дахь зах зээл нээгдэх хүртэл бусдад худалдах, шилжүүлэхгүй байхаар заасан болохыг анхаарна уу.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 04 сарын 25-ны өдрийн 137 тоот тогтоолоор “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлэв.
- “Мик холдинг” ХК Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 37,2 тэрбум төгрөг буюу манай биржийн түүхэн дэх хамгийн өндөр үнийн дүн бүхий IPO-г амжилттай хэрэгжүүлсэн болохыг өмнө мэдээлж байсан билээ.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 4-р сарын арилжааны мэдээ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Мягмар гарагаас дараа долоо хоногийн Даваа гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Дөрөвдүгээр сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж нийт 42.7 тэрбум төгрөгийн богино болон урт хугацаат ГЗҮЦ-ыг арилжаалсан байна.

Өдөр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2016.04.04	28	100,000	14.05%	9,298,000,000.00
2016.04.11	39	100,000	14.394%	9,028,000,000.00
2016.04.18	52	100,000	14.318%	8,750,500,000.00
2016.04.18	156	19,995	15,750%	1,999,500,000.00
2016.04.25	12	120,000	13.190%	11,646,480,000.00
2016.04.25	104	19,995	15.500%	1,999,500,000.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ		459,990		42,722,480,000.00

ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны хоёрдогч үнэт цаасны арилжаа 2016 оны 3 сард нийт 4 удаа явагдаж 1,541 ширхэг буюу 152,2 сая төгрөгний ЗГҮЦ-ны гүйлгээ хийсэн байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Нэгжийн үнэ	Үнийн дүн / төгрөг/
2016.04.20	ZGEB-BL-16/05/16-A0111-0	903	99,030	89,424,090.00
2016.04.20	ZGEB-BL-24/05/16-A0073-0	200	98,740	19,748,000.00
2016.04.20	ZGEB-BL-24/05/16-A0073-0	332	98.740	32,781,680.00
2016.04.26	ZGEB-BL-05/07/16-A0088-0	4106	97,500	10,335,000.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ		1,541		152,288,770.00

“МОНГОЛ-ЛОНДОНГИЙН БИЗНЕС ФОРУМ” БОЛЖ ӨНГӨРЛӨӨ



Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран 5 дахь жилдээ “Монгол-Лондонгийн бизнес форум”-ыг 2016 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өнгөрлөө.

Энэхүү форумд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Худалдаа Аж Үйлдвэрийн Яам, Англи-Монголын худалдааны танхим, олон улсын байгууллагууд, Монголын компаниуд, хөрөнгийн зах зээл дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулагч Монгол, Английн хөрөнгө оруулагчид, бизнесмэнүүд зэрэг нийт 120 гаруй төлөөлөлөгч оролцсон байна.

Энэхүү форумын үеэр хоёр орны хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар харилцан мэдээлэл солилцож, Монголын талаас тэргүүлэх чиглэлийн салбар болон хэрэгжүүлэх нэн шаардлагатай төслүүдийн талаар танилцуулга хийгдсэн билээ.

"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК-ИЙН 1072 ШИРХЭГ ХУВЬЦААНЫ ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоол, 2012 оны 116 дугаар тогтоолуудаар иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолуудын хүрээнд тус компанийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэж, баталгаажуулсан болно.

Өөрөөр хэлбэл "Эрдэнэс Тавантолгой" ХК нь хаалттай хувьцаат компани буюу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны арилжаа эхлээгүй компани юм.

Гэтэл сүүлийн үед үнэт цаас эзэмших дансыг яаралтай нээлгэснээр "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа, түүнийг өмчлөх эрх нь баталгаажих, ингэснээр мөнгө болох мэтээр иргэдийг төөрөгдүүлсэн худал мэдээлэл тарааж, түүгээр далимдуулан үнэт цаасны данс нээж буй талаар иргэдээс Монголын хөрөнгийн биржид хандан лавлагаа авах, мэдээлэл ирүүлэх боллоо.

Үнэт цаасны арилжаанд оролцох, хувьцаа худалдах болон худалдаж авах зорилгоор Хорооноос тусгай зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан үнэт цаасны дансыг нээлгэх эрх нь иргэдэд нээлттэй хэдий боловч зөвхөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг эзэмших, түүнийг бусдад арилжаалахтай холбоотойгоор нэн даруй данс нээлгэх шаардлагагүй болохыг мэдэгдэж байна.

Иргэн таны эзэмшиж буй "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны хувьд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын 2.3-т Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг түүний хоёр дахь зах зээл нээгдэх хүртэл бусдад худалдах, шилжүүлэхгүй байхаар заасан болохыг анхаарна уу.

СТАНДАРТ ИНВЕСМЕНТ ҮЦК-ИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭВ

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 04 сарын 25-ны өдрийн 137 тоот тогтоолоор "Стандарт инвестмент ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлэв.

“МИК ХОЛДИНГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

“Мик холдинг” ХК Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 37.2 тэрбум төгрөг буюу манай биржийн түүхэн дэх хамгийн өндөр үнийн дүн бүхий IPO-г амжилттай хэрэгжүүлсэн болохыг өмнө мэдээлж байсан билээ.

Монголын хөрөнгийн бирж өөрийгээ зохицуулах байгууллага болсноор зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө босгогчийн үнэт цаасны бүртгэлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган олон нийт болон зах зээлд оролцогчдын итгэл үнэмшлийг хадгалах үүрэг зорилтын хүрээнд “Мик холдинг” ХК-ийн үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад Хяналт шалгалтын албанаас нарийвчилсан шалгалт хийв.

2016 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хийсэн энэ шалгалтаар “Мик холдинг” ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн захиран зарцуулалтыг санхүүгийн баримтад үндэслэн шалгаж, тайлбар, тодруулга авч ажилласнаар уг босгосон хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад анх тусгагдсан төсөл, зориулалтын дагуу ашиглаж байна гэж ажлын хэсэг дүгнэсэн ба зээлийн багц худалдан авах үйл явц нь арилжааны банкуудын саналыг судлах, компанийн өөрийн дотоод ажлын үе шат, үйл ажиллагааны процедурын дагуу тодорхой цаг хугацааг зарцуулжээ.

Одоогийн байдлаар 2.3 тэрбум төгрөгийн зээлийн багцыг худалдан аваад байгаа ба нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөр зээлийн багц худалдах талаар арилжааны банкуудын ирүүлсэн саналын дагуу хэлцэл хийх хуваарийг сар бүрээр төлөвлөн хэрэгжүүлэхээр ажиллаж байгаатай газар дээр нь танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгч, биржэд бүртгэлтэй хувьцаат компанийн бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, цаашид хамтран ажиллах талаар харилцан санал бодлоо солилцон ажиллаа.

“Мик холдинг” ХК-нь үнэт цаасаа олон нийтэд санал болгож анхдагч зах зээлд амжилттай арилжсан ба цаашид хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг хадгалж хөрөнгийн зах зээлийг сонгодог утгаар хөгжихөд нэг түүчээ болж явах үнэт цаас гаргагч гэж дүгнэж байна.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2016 оны 4 дүгээр сарын 25-наас 4 дүгээр сарын 29-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	10,195,920
Нийт үнийн дүн /төг/	46,612,406,961
Хэлцлийн тоо	1,220
Арилжигдсан үнэт цаасны тоо	67
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,267,337,526,632

ТОП-20 индекс

Хаалт	10,841.95
Өөрчлөлт /%/	-2.17

MSE ALL индекс

Хаалт	769.31
Өөрчлөлт /%/	-4.19



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	7,761,274	1	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	2,275,295,460
2	RMC	РЕМИКОН	721,979	2	TTL	ТАВАН ТОЛГОЙ	388,930,805
3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	441,627	3	APU	АПУ	250,021,200
4	MRX	МЕРЕКС	145,907	4	APU	АПУ	239,318,130
5	JTB	Ж ЕНКО ТУР БЮРО	120,631	5	TSA	ЦАГААНТОЛГОЙ	214,559,920

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	TTL	ТАВАН ТОЛГОЙ	1,336.00		53.56
2	RMC	РЕМИКОН	57.50		15.00
3	CHR	УВС ЧАЦАРГАНА	920.00		15.00
4	HSR	ХАСУ-МАНДАЛ	4,020.00		14.86
5	AOI	АВТО ИМПЕКС	2,410.00		14.82

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	TSA	ЦАГААНТОЛГОЙ	3,600.00		-36.34
2	MBG	МОН-ИТ БУЛИГААР	7,650.00		-23.50
3	MVO	МОНГОЛ ШЕВРО	1,600.00		-22.48
4	UYN	МОНГОЛ САВХИ	511.00		-21.38
5	MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	4,001.00		-19.98

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-28-368	100,000	9,298,500,000	92,985	28	14.050
2	ЗГХБ-Б-39-371	100,000	9,028,000,000	90,280	39	14.394
3	ЗГХБ-Б-52-373	100,000	8,750,500,000	87,505	52	14.318
4	ЗГЭБ-У-156-374	19,995	1,999,500,000	100,000	156	15.750
5	ЗГХБ-Б-12-375	120,000	11,646,480,000	97,054	12	13.190
6	ЗГЭБ-У-104-376	19,995	1,999,500,000	100,000	104	15.500

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлчийн ханш
1	ZGEB-BL-16/05/16-A0111-0	903	89,424,090	99,030	99,030	99,030
2	ZGEB-BL-24/05/16-A0073-0	200	19,748,000	98,740	98,740	98,740
3	ZGEB-BL-24/05/16-A0073-0	332	32,781,680	98,740	98,740	98,740
4	ZGEB-BL-05/07/16-A0088-0	106	10,335,000	97,500	97,500	97,500